



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ КЛИРИНГИЙН ТӨВ ХХК-ИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/51/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Аудитор: Ц.Цэрэнхүү  
Утас: 261740 Цахим хаяг: [tserenkhuuts@audit.gov.mn](mailto:tserenkhuuts@audit.gov.mn)  
Гэрээгээр гүйцэтгэсэн: "Лидер экаунт аудит" ХХК-ийн  
Захирал П.Шаравхорол  
Утас: 70114519  
Цахим хаяг: [leaderaudit.20@gmail.com](mailto:leaderaudit.20@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

**Агуулга**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал.....	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
8. Аудитын илрүүлэлт .....	14
8.1 Залруулсан алдаа .....	14
8.2 Зөвлөмж.....	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/588  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ  
КЛИРИНГИЙН ТӨВ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
О.ЭРДЭНЭГЭРЭЛ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Байгууллага нь нийт орлогыг 553.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 543.0 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 9.7 сая төгрөгөөр тогтоож төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 845.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 530.9 сая төгрөгийн зардал гарган 283.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний 3 худалдан авах ажиллагаанд 1,568.3 сая төгрөг төлөвлөснөөс 6.8 сая төгрөгөөр зөөврийн компьютер худалдан авч, 1,561.5 сая төгрөгийн үнэт цаасны клиринг, эрсдэлийн менежментийн систем худалдан авах ажил хийгдээгүй байна. Энэ нь Сангийн яамнаас хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд болох Монголын хөрөнгийн бирж ТӨХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК, Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-иудын үйл ажиллагаанд хэрэглэгдэх нэгдсэн системийг хийхээр шийдвэрлэсэнтэй холбоотой байна.

\\10-10-10.20\Bichig\_Kherag\Yawsan\_Bichig\2022\0315 Auditin 2 Газар - 69.Docx

001050918

## Бусад асуудал

Клирингийн төлбөр тооцооны орлого, зарлагын гүйлгээг хөтөлдөг E-clearing house систем, санхүүгийн программ хангамжийн хоорондын уялдааг хангасан нэгдсэн санхүүгийн программ хангамжтай болох шаардлагатай байна.

## Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус компани 2021 оны бизнес төлөвлөгөөнд нийт 79 ажил төлөвлөснөөс байгууллагын орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд үйлчлэх урамшууллын оновчтой системийг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэх, клирингийн үйлчилгээ үзүүлэх арилжааны хэмжээг нэмэгдүүлэх замаар орлого нэмэгдүүлэх гэсэн ажлууд биелэгдээгүй, төлөвлөгөөт ажлын биелэлт 98.7 хувь байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig\_Kherag\Yawsan\_Bichig\2021\210315 Auditlin 2 Газар - 69.Docx

ТӨВ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

О.ЭРДЭНЭГЭРЭЛ ТАНАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,713,003,411.82	3,944,481,358.19
1.1.2	Дансны авлага	20,213,601.07	15,341,882.01
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	7,649,301.86	3,707,054.98
1.1.4	Бусад авлага	-	30,000.00
1.1.6	Бараа материал	2,854,960.00	4,213,161.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,042,000.00	4,009,687.50
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>3,748,763,274.75</b>	<b>3,971,783,143.68</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	69,056,881.76	62,274,210.76
1.2.2	Биет бус хөрөнгө	96,430,242.43	95,547,850.43
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	4,711,002.59	7,191,468.15
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>170,198,126.78</b>	<b>165,013,529.34</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,918,961,401.53</b>	<b>4,136,796,673.02</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	383,174.19	962,300.90
2.1.1.3	Татварын өр	-	156,692.44
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.7	Харилцагчдад өгөх өглөг	271,399,722.55	147,998,223.98
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	657,376,141.02	713,910,982.25
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>929,159,037.76</b>	<b>863,028,199.57</b>
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	4,711,002.59	7,191,468.15
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>933,870,040.35</b>	<b>870,219,667.72</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	2,000,000,020.75	2,000,000,020.75
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9,560,000.00	7,160,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	975,531,340.43	1,259,416,984.55
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>2,985,091,361.18</b>	<b>3,266,577,005.30</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,918,961,401.53</b>	<b>4,136,796,673.02</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан***2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан**/төгрөгөөр/*

<b>Мөрийн дугаар</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>2020 оны 12-р сарын 31</b>	<b>2021 оны 12-р сарын 31</b>
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>406,439,663.43</b>	<b>845,524,032.61</b>
2	Борлуулалтын өртөг	-	-
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>406,439,663.43</b>	<b>845,524,032.61</b>
4	Арилжааны шимтгэлийн орлого	169,120,001.74	712,822,559.46
5	Хүүгийн орлого	237,254,981.69	132,701,473.15
8	Бусад орлого	64,680.00	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	477,915,886.81	530,903,423.55
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	34,249.69
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(71,476,223.38)</b>	<b>314,654,858.75</b>
19	Орлогын татварын зардал	23,725,498.17	31,465,485.87
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(95,201,721.55)</b>	<b>283,189,372.88</b>
<b>24</b>	<b>Орлогын дүн</b>	<b>(95,201,721.55)</b>	<b>283,189,372.88</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан***2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан**/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,000,000,020.75</b>	<b>9,560,000.00</b>	<b>1,111,653,061.98</b>	<b>5,121,213,082.73</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			95,201,721.55	<b>95,201,721.55</b>
Өмчид гарсан өөрчлөлт	(2,000,000,000.00)			<b>(2,000,000,000.00)</b>
Зарласан ногдол ашиг			(40,920,000.00)	<b>(40,920,000.00)</b>
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>9,560,000.00</b>	<b>975,531,340.43</b>	<b>2,985,091,361.18</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			696,271.24	696,271.24
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>9,560,000.00</b>	<b>976,227,611.67</b>	<b>2,985,787,632.42</b>
Үндсэн хөрөнгө дахин үнэлгээний өсөлт бууралт		(2,400,000.00)		<b>(2,400,000.00)</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			283,189,372.88	<b>283,189,372.88</b>
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>7,160,000.00</b>	<b>1,259,416,984.55</b>	<b>3,266,577,005.30</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>23,818,154,450.97</b>	<b>42,885,530,124.92</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	166,014,368.34	712,822,559.46
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	9,210,930.00	17,009,097.00
	Бусад мөнгөн орлого	23,642,929,152.63	42,155,698,468.46
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (+)</b>	<b>25,576,370,951.83</b>	<b>42,768,675,783.70</b>
	Ажиллагчдад төлсөн	258,038,452.29	289,434,334.30
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	77,484,292.41	42,557,588.72
	Бараа материал худалдан авахад төлсөн	5,639,652.27	3,983,816.05
	Ашиглалтын зардалд төлсөн	20,551,861.79	20,279,376.58
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,591,340.00	3,264,400.00
	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн	26,793,270.77	197,396,388.27
	Татварын байгууллагад төлсөн	66,620,314.34	62,632,815.55
	Даатгалын төлбөрт төлсөн	9,210,930.00	400,000.00
	Бусад мөнгөн зарлага	25,107,440,837.96	42,148,727,064.23
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,758,216,500.86)</b>	<b>116,854,341.22</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	220,249,654.44	132,701,473.15
	Хүлээн авсан хүүгийн орлого	220,249,654.44	132,701,473.15
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>2,328,000.00</b>	<b>18,077,868.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,328,000.00	18,077,868.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>217,921,654.44</b>	<b>114,623,605.15</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.2	Мөнгөн зарлагын дүн	<b>40,920,000.00</b>	-
	Төлсөн ногдол ашиг	40,920,000.00	-
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,581,214,846.42)</b>	<b>231,477,946.37</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>5,294,218,258.24</b>	<b>3,713,003,411.82</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,713,003,411.82</b>	<b>3,944,481,358.19</b>



**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл***/мянган төгрөгөөр/*

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>A</b>	<b>Үйл ажиллагааны нийт орлого</b>	<b>406,439.7</b>	<b>553,720.1</b>	<b>845,524.0</b>	<b>(291,803.9)</b>	<b>152.7</b>
1	Арилжааны шимтгэл	158,120.0	437,129.1	682,822.5	(245,693.4)	156.2
2	Гишүүний жилийн хураамж	11,000.0	16,100.0	30,000.0	(13,900.0)	186.3
3	Хүүгийн орлого	237,319.7	100,491.0	132,701.5	(32,210.5)	132.1
<b>Б</b>	<b>Үйл ажиллагааны нийт зардал</b>	<b>477,915.9</b>	<b>543,017.0</b>	<b>530,903.3</b>	<b>12,113.7</b>	<b>97.8</b>
1	Үйл ажиллагааны зардал	441,102.0	515,587.0	505,160.4	10,426.6	98.0
2	Элэгдлийн зардал	36,813.9	27,430.0	25,742.9	1,687.1	93.8
<b>В</b>	<b>Үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>(71,476.2)</b>	<b>10,703.1</b>	<b>314,620.7</b>	<b>(303,917.6)</b>	<b>2,939.5</b>
2	Татварын өмнөх ашиг (алдагдал)	(71,476.2)	10,703.1	314,620.7	(303,917.6)	2,939.5
3	Орлогын татвар	23,725.5	1,004.9	31,462.1	(30,457.2)	3,130.8
4	Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)	(95,201.7)	9,698.2	283,158.6	(273,460.4)	2,919.5
7	Ажиллагсдын тоо	16	16	16	-	-
8	Хөрөнгө оруулалт	2,328.0	1,568,300.0	6,800.0	(1,561,500.0)	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөдөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны цахим баримт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 11-ний хооронд Лидер экаунт аудит ХХК-ийн ахлах аудитор Ш.Уянга, аудитор Ч.Отгонцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал П.Шаравхорол хэрэгжүүлсэн.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Лидер экаунт аудит ХХК-д 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 01/39 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, цаашид шинэчилсэн хууль, журамд нийцүүлэн сайжруулах шаардлагатай байна.

Компанийн дотоод хяналт шалгалтын ажилтан нь 2021 онд 23 ажлын хүрээнд нийт 107 ажил хийхээр төлөвлөж, түүнийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналт шалгалтыг санхүү нягтлан бодох бүртгэлийн болон үйл ажиллагааны чиглэлээр ангилан гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 406.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн зорилго нь үнэт цаасны болон мөнгөн төлбөрийн үүргийг гэрээ тус бүрээр, нэгдсэн дүнгээр тодорхойлох клирингийн үндсэн үйл ажиллагаа, тэрхүү төлбөрийн үүрэг бүрэн биелэгдэхтэй холбоотой болзошгүй эрсдэлийг удирдах үйл ажиллагааг олон улсын стандартын дагуу зохистой гүйцэтгэж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн тогтвортой өсөлтийг дэмжихэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа;
- Тооцооны байгууллага нь гишүүнчлэлтэй байх бөгөөд үнэт цаасны арилжааны явцад хийгдсэн гэрээ, хэлцэл цуцлагдах аливаа эрсдэлийг бууруулах тусгай сан байгуулж ажиллах;
- Тооцооны байгууллага нь үнэт цаасны зах зээлийн тогтолцооны эрсдэлийг шинжилж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаарх зөвлөмжөөр үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг хангах.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Монголын үнэт цаасны клирингийн төв үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа эрхлэх хязгаарлагдмал хариуцлагатай компанийн статустай байна. Өмчийг 100 хувийг төр эзэмших бөгөөд хувьцаа эзэмшигч нь Засгийн газраас эрх олгосон этгээд буюу Сангийн яам байна.

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь Засгийн газрын 2016 оны 1 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн дүрэмд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгож, чөлөөлдөг ба компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний эрх, үүргийг тогтоох, томилох чөлөөлөх эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлж байна.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 450.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Монголын хөрөнгийн биржийн арилжаа өссөнөөс гадна компанийн арилжааны шимтгэлийн орлого цэвэршүүлсэн биш худалдсан болон худалдан авсан тал тус бүрээс тооцдог болсон, компани үйл ажиллагаандаа Олон улсын зарчмыг нэвтрүүлэн зах зээлд оролцогч нартай нягт хамтран ажилласнаар төлөвлөсөн ажлаа бүрэн биелүүлж, 845.5 сая төгрөгийн орлого олж, 283.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;” гэж заасны дагуу байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт ороогүй, батлагдсан төлөвлөгөөт зардлыг 2.2 хувиар буюу 12.1 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 01 дугаар тушаал “Үнэт цаасны клирингийн журам”;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 01 дугаар тушаал “Компанийн мэдээллийн технологид үүссэн онцгой байдлын үед авах арга хэмжээний журам”;

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,713,003.4	3,944,481.3	231,477.9
Авлага	20,213.6	15,341.9	(4,871.7)
Татвар, НДШ-ийн авлага	7,649.3	3,707.1	(3,942.2)
Бусад авлага	-	30.0	30.0
Урьдчилгаа	5,042.0	4,009.7	(1,032.3)
Бараа материал	2,855.0	4,213.2	1,358.2
Үндсэн хөрөнгө	69,056.9	62,274.2	(6,782.7)
Биет бус хөрөнгө	96,430.2	95,547.8	(882.4)

Хойшлогдсон татварын хөрөнгө	4,711.0	7,191.4	2,480.4
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,918,961.4</b>	<b>4,136,796.6</b>	<b>217,835.2</b>
Богино хугацаат өр төлбөр	929,159.0	863,028.1	(66,130.9)
Урт хугацаат өр төлбөр	4,711.0	7,191.5	2,480.5
Эздийн өмч	2,985,091.4	3,266,577.0	281,485.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,918,961.4</b>	<b>4,136,796.6</b>	<b>217,835.2</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,944.5 сая төгрөг болж, үүний 0.2 сая төгрөг нь касс дахь бэлэн мөнгө, 2,022.1 сая төгрөг нь банкин дахь харилцах дансны үлдэгдэл, 1,913.2 сая төгрөг нь хугацаатай хадгаламжийн үлдэгдэл, 9.0 сая төгрөг нь замд яваа мөнгө байна.

Авлага дансны үлдэгдэл 15.3 сая төгрөг болж өмнөх оноос 4.9 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд авлагаар бүртгэгдсэн арилжааны шимтгэлийн авлага хүлээн авсантай холбоотой байна. Мөн авлагын үлдэгдэл 15.3 сая төгрөг нь хугацаатай хадгаламжийн хүүгийн авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 62.3 сая төгрөг болж өмнөх оноос 6.8 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 6.8 сая төгрөгөөр зөөврийн компьютер худалдан авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Мицубиши маркийн автобусыг “Баянчандмань АЗЗА” ТӨҮГ-т шилжүүлсэн байна.

Биет бус хөрөнгө 0.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд гарцын төхөөрөмжийн сунгалтын лиценз 11.3 сая төгрөгөөр худалдан авч, 12.2 сая төгрөгийн биет бус хөрөнгийн хорогдол тооцож бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 863.0 сая төгрөг болж 66.2 сая төгрөгөөр буурсан нь арилжаанд оролцогчдын барьцаа хөрөнгө 123.5 сая төгрөгөөр буурсан, барьцаа хөрөнгийн өглөг 52.6 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сангийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 200 дугаар тушаалаар тус компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 553.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 543.0 сая төгрөгөөр, 10.7 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,568.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 845.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 530.9 сая төгрөгийн зардал гарган, 283.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 845.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 291.8 сая төгрөг буюу 52.7 хувиар давсан арилжааны шимтгэлийн орлого төлөвлөснөөс 245.7 сая төгрөг буюу 56.2 хувиар давж биелэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 530.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 12.1 сая төгрөг буюу 2.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь шуудан холбоо, тээвэр шатахууны зардлыг хэмнэлттэй зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Үнэт цаасны клиринг, эрсдэлийн менежментийн систем худалдан авах болон бодлогын даалгавар боловсруулах үйл ажиллагаанд зориулан хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд 1,561.5 сая төгрөгийг тусгасан ч хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд цэвэр ашиг 283.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 273.5 сая төгрөгөөр илүү байгаа нь арилжааны шимтгэлийн орлого 56.2 хувиар давж биелэгдсэн нь нөлөөлж байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК нь тайлант онд нийт 4,687.8 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас зорилтот түвшин түүний гүйцэтгэл, зардлын хэтрэлт, хэмнэлтийн талаарх 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул холбогдох ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үйл ажиллагааны зардалд 23.5 сая төгрөг, программ хангамжийн зардалд 1,589.4 сая төгрөг, тоног төхөөрөмжийн зардалд 6.8 сая төгрөг нийт 1,619.7 сая төгрөг тусгагдсан байна. Гүйцэтгэлээр лицензийн зардалд 11.3 сая төгрөг, зөөврийн компьютер худалдан авахад 6.8 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 16.5 сая төгрөг нийт 34.6 сая төгрөгийг зарцуулсан нь төлөвлөгөөт зардлын 2.1 хувь болж байна. Үнэт цаасны клиринг, эрсдэлийн менежментийн систем худалдан авах зардалд 1,561.5 сая төгрөгийг төлөвлөсөн ч хэрэгжүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар 62.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор элэгдлээрээ өртгөө нөхсөн 62.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах асуудлыг байгууллагын Өмч хамгаалах комиссын хурлаар авч

хэлэлцэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлэсэн тул санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгаагүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 18 мэдээллийн хугацааг хоцроосон зөрчилд албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 139 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй тул холбогдох ажилтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг Төлөөлөн удирдах зөвлөл болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлсэн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх.

## **8. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 5.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.7 сая төгрөгийн алдааг залруулж, 4.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### **8.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1.7 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлангийн ААНОАТ-ын авлагын дансны үлдэгдэл татварын цахим тайлангийн үлдэгдэлтэй 1.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

### **8.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тус компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/60 тоот тушаалаар баталж, мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэчлэгдсэн хууль, журмын өөрчлөлтийг бүрэн тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үнэт цаасны клирингийн журам болон холбогдох стандарттай нийцүүлэн шинэчилж, мөрдөх.

#### **2. Цахим баримттай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Татварын цахим төлбөрийн баримтын системд 4.0 сая төгрөгийн орлогын и-баримт илүү шивсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад

хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтууд, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Татварын цахим төлбөрийн баримтын системд баримт илүү шивсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, орлого, зарлагын баримтыг тулган шалгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>																
1	Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК	АХГ-2022/51/НА-СТА-ТӨА	Санхүүгийн байдлын тайлангийн ААНОАТ-ын авлагын дансны үлдэгдэл татварын цахим тайлангийн үлдэгдэлтэй 1,703.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	Санхүүгийн байдлын тайланд ААНОАТ-ын авлагын дүнг залруулах	1	1,703.7	1	1,703.7								
2	Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК	АХГ-2022/51/НА-СТА-ТӨА	Тус компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/60 тоот тушаалаар баталж, мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэчлэгдсэн хууль, журмын өөрчлөлтийг бүрэн тусгаагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үнэт цаасны клирингийн журам болон холбогдох стандарттай нийцүүлэн шинэчилж, мөрдөх.	1	-								1	-	
3	Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК	АХГ-2022/51/НА-СТА-ТӨА	Татварын цахим төлбөрийн баримтын системд 4,008.0 мянган төгрөгийн орлогын и-баримт илүү шивсэн байна.	Татварын цахим төлбөрийн баримтын системд баримт илүү шивсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, орлого, зарлагын баримтыг тулган шалгаж байх.	1	4,008.0								1	4,008.0	
<b>ДҮН</b>					<b>3</b>	<b>5,711.7</b>	<b>1</b>	<b>1,703.7</b>	-	-	-	-	-	-	<b>2</b>	<b>4,008.0</b>
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал</b>																
1	Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК	АХГ-2022/51/НА-СТА-ТӨА	Тайлант онд нийт 139 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулснаас зорилтод түвшин түүний гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн талаарх 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.	1	-							1	-		
<b>ДҮН</b>					<b>1</b>	<b>-</b>							<b>1</b>	<b>-</b>		
<b>НИЙТ ДҮН</b>					<b>4</b>	<b>5,711.7</b>	<b>1</b>	<b>1,703.7</b>	-	-	-	-	<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>4,008.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 445/АДИСООСЗ  
АХГ-2022/51/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 4,687,858,755.55 төгрөгийн ажил, гүйлгээний 136 мэдээллийг ил тод байршуулахаас зорилтот түвшин түүний гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн талаарх 5 мэдээллийг хугацаа хоцроосон, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг гүйцэтгэх захирал О.Эрдэнэгэрэлд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
 АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
 ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
 АХЛАХ АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ  
 Д ЭНХДАЛАЙ  
 Ш УЯНГА

4006104  
 9019120596

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\hichig\_khereg\Alban\_Shaardlaga\2022\0313\_Auditin\_2\_Gazar-135.Docx

001081264





